



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/532

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн  
төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2, 35.1.3, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2017 оны "Захиалагчийн дүрэм батлах тухай" 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны "Журам батлах тухай" 160 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны "Нээлттэй тендер шалгаруулалтаар ажил худалдан авах жишиг баримт бичиг батлах тухай" 145 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжихээр батлагдсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд Мөрөн сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ХӨАОНӨГ/202312072 дугаартай төсөл арга хэмжээний Багц-1 "Мөрөн сумын 2 дугаар баг 7 дугаар цэцэрлэгийн урдаас 2 дугаар багийн хатуу хучилттай авто замын уулзвар хүртэл ногоон зурвас байгуулах/ тендерт 185,285,334 (Нэг зуун наян таван сая хоёр зуун наян таван мянга гурван зуун гучин дөрвөн) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Жигүүр Ой" ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Жигүүр Ой" ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГазар (Д.Батчулуун)-ыг томилсугай.


3. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд Мөрөн сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх Багц-1 "Мөрөн сумын 2 дугаар баг 7 дугаар цэцэрлэгийн урдаас 2 дугаар багийн хатуу хучилттай авто замын уулзвар хүртэл ногоон зурвас байгуулах/ ажил нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатны хяналт хийх, ил далд ажлын актыг баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэх, барилгын ажлын үе шатанд хяналт хийж, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тайлагнах, уг тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГазар (Д.Батчулуун)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, барилга байгууламжийг

ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Барилгын ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг гэрээний дагуу "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-т барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар-т тус тус олгохыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ